

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/216/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 9938220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.09.24 № 01/126
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН
СУМЫН ЕСДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.НАРАНХҮҮ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Есдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Есдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,383,354.06</u>	<u>73,095,691.26</u>
33	АВЛАГА		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,674,640.00	00.00
		200,000.00	00.00
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага	3,474,640.00	00.00
		3,474,640.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ		
351	Түүхий эд материал		
35130	Эм боох материал	74,708,714.06	73,095,691.26
		2,855,250.00	1,830,030.00
354	Хангамжийн материал		
35420	Аж ахуйн материал	71,853,464.06	71,265,661.26
		221,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	5,610,000.00	1,100,000.00
35450	Барилгын засварын материал	731,000.00	611,000.00
35460	Хүнсний материал	1,557,145.80	3,483,043.00
35470	Бусад хангамжийн материал	63,734,318.26	66,071,618.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>689,909,320.08</u>	<u>710,958,317.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
392	Биет хөрөнгө		
39201	Барилга, байгууламж, орон сууц	689,909,320.08	710,958,317.27
		652,409,320.08	673,141,517.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	626,379,781.93	626,379,781.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-25,888,116.96	-38,832,175.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	68,681,106.82	69,844,286.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-38,107,060.58	-11,642,094.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	19,687,513.16	25,024,575.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	-8,973,934.84	-9,035,511.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	13,818,953.19	12,618,953.19
39217	Ном	-5,468,642.64	-1,216,297.32
		2,279,720.00	00.00
393	Биет бус хөрөнгө		
39301	Програм хангамж	37,500,000.00	37,816,800.00
		792,000.00	316,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-792,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	37,500,000.00	37,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>768,292,674.14</u>	<u>784,054,008.53</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>768,292,674.14</u>	<u>784,054,008.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	768,292,674.14	784,054,008.53
51101	Өмч: - төрийн	327,078,090.00	327,078,090.00
		327,078,090.00	327,078,090.00
512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	284,422,657.43	300,227,021.10
51220	Тайлант үеийн үр дүн	284,422,657.43	284,465,686.71
		00.00	15,761,334.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	156,791,926.71	156,748,897.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>768,292,674.14</u>	<u>784,054,008.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	539,663,440.00	516,468,334.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,256,240.00	25,843,234.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,256,240.00	25,843,234.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,256,240.00	25,843,234.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,256,240.00	25,843,234.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	516,407,200.00	490,625,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	450,609,300.00	433,898,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	550,000.00	1,873,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	1,261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	612,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,247,900.00	54,852,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,247,900.00	54,852,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	514,202,218.63	498,427,279.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,202,218.63	498,427,279.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,383,888.05	491,971,398.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,811,220.00	335,425,723.00
210101	Үндсэн цалин	242,264,520.00	216,707,123.00
210102	Нэмэгдэл	41,659,900.00	89,983,200.00
210104	Урамшуулал	23,886,800.00	28,735,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,796,294.15	43,445,140.15
210201	Тэтгэврийн даатгал	26,592,353.70	31,333,645.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,128,512.20	3,413,059.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,489.76	2,683,406.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,267.78	546,821.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,102,670.71	5,468,209.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,909,305.27	53,710,035.38
210301	Гэрэл, цахилгаан	1,917,955.27	2,122,347.74
210302	Түлш, халаалт	46,491,350.00	48,190,117.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,397,570.64
2104	Хангамж, бараа материалын зардал	11,085,409.00	5,380,040.00
210401	Бичиг хэрэг	634,600.00	253,000.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,147,300.00	1,164,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,141,000.00	468,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,612,509.00	3,144,840.00
2105	Нормативт зардал	22,001,490.00	14,201,667.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	869,050.00	1,303,420.00
210502	Хоол, хүнс	19,695,840.00	12,054,847.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,436,600.00	843,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,996,300.00	4,667,300.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	6,996,300.00	4,667,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,112,500.00	1,950,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	812,500.00	1,230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,671,369.63	33,191,491.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,161,094.38	5,622,955.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,925,300.00	3,048,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,584,975.25	24,520,516.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,818,330.58	6,455,881.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	560,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,251,294.73	1,105,364.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,251,294.73	1,105,364.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,007,035.85	5,250,516.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,007,035.85	5,250,516.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	25,461,221.37	18,041,054.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,279,720.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,279,720.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,279,720.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	25,461,221.37	15,761,334.39

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,078,090.00	156,791,926.71	258,961,436.06	742,831,452.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,078,090.00	156,791,926.71	258,961,436.06	742,831,452.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,461,221.37	25,461,221.37
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,078,090.00	156,791,926.71	284,422,657.43	768,292,674.14
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,078,090.00	156,791,926.71	284,422,657.43	768,292,674.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	43,029.28	43,029.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,078,090.00	156,791,926.71	284,465,686.71	768,335,703.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-43,029.28	00.00	-43,029.28
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,761,334.39	15,761,334.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,078,090.00	156,748,897.43	300,227,021.10	784,054,008.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	516,407,200.00	490,825,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	516,407,200.00	490,825,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	450,609,300.00	433,898,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	550,000.00	2,073,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	1,261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	812,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,247,900.00	54,852,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,247,900.00	54,852,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	494,339,600.00	465,025,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,339,600.00	465,025,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,321,269.42	458,569,218.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,811,220.00	335,425,723.00
210101	Үндсэн цалин	242,264,520.00	216,707,123.00
210102	Нэмэгдэл	41,659,900.00	89,983,200.00
210104	Урамшуулал	23,886,800.00	28,735,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,796,294.15	43,445,140.15
210201	Тэтгэврийн даатгал	26,592,353.71	31,333,645.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,128,512.20	3,413,059.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,489.76	2,683,406.00
210204	Ажилгүйдлийн даатгал	510,267.78	546,821.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,102,670.70	5,468,209.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн ЛӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,269,305.27	49,200,035.38
210301	Гэрэл, цахилгаан	1,917,955.27	2,122,347.74
210302	Түлш, халаалт	50,851,350.00	43,680,117.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,397,570.64
2104	Хангамж, бараа материалын зардал	13,869,300.00	6,312,200.00
210401	Бичиг хэрэг	584,600.00	253,000.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,147,300.00	1,164,200.00
210404	Ном, хэвлэл	237,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,362,000.00	573,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,988,200.00	3,972,000.00
2105	Нормативт зардал	31,279,850.00	12,260,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,694,900.00	84,300.00
210502	Хоол, хүнс	16,916,150.00	11,333,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,668,800.00	843,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,727,300.00	4,547,300.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	7,727,300.00	4,547,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,112,500.00	1,950,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	812,500.00	1,230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,455,500.00	5,427,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	711,600.00	2,054,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,743,900.00	3,373,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,018,330.58	6,455,881.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	560,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,451,294.73	1,105,364.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,451,294.73	1,105,364.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,007,035.85	5,250,516.85
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,007,035.85	5,250,516.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,067,600.00</u>	<u>25,800,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,067,600.00	25,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,067,600.00	25,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,067,600.00	25,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,067,600.00	25,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-22,067,600.00</u>	<u>-25,800,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488,751,300.00	482,395,418.53	6,355,881.47	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,751,300.00	482,395,418.53	6,355,881.47	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,751,300.00	482,395,418.53	6,355,881.47	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,312,400.00	335,425,723.00	886,677.00	99.7
210101	Үндсэн цалин	217,593,800.00	216,707,123.00	886,677.00	99.6
210102	Нэмэгдэл	89,983,200.00	89,983,200.00	00.00	100.0
210104	Урамшуулал	28,735,400.00	28,735,400.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,402,100.00	43,445,140.15	1,956,959.85	95.7
210201	Тэтгэврийн даатгал	31,949,600.00	31,333,645.02	615,954.98	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,363,100.00	3,413,059.13	-49,959.13	101.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,690,500.00	2,683,406.00	7,094.00	99.7
210204	Ажилгүйдлийн даатгал	672,600.00	546,821.00	125,779.00	81.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,726,300.00	5,468,209.00	1,258,091.00	81.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,305,400.00	49,200,035.38	1,105,364.62	97.8
210301	Гэрэл, цахилгаан	2,630,000.00	2,122,347.74	507,652.26	80.7
210302	Түлш, халаалт	44,125,400.00	43,680,117.00	445,283.00	99.0
210303	Цэвэр, бохир ус	3,550,000.00	3,397,570.64	152,429.36	95.7
2104	Хангамж, бараа материалын зардал	5,000,400.00	5,000,400.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	253,000.00	253,000.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,164,200.00	1,164,200.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,283,200.00	3,283,200.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	14,667,800.00	12,260,920.00	2,406,880.00	83.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,300.00	84,300.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	13,740,100.00	11,333,220.00	2,406,880.00	82.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	843,400.00	843,400.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,347,300.00	30,347,300.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,500,000.00	00.00	100.0
210602	Тавилга	6,300,000.00	6,300,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	4,547,300.00	4,547,300.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,710,000.00	1,710,000.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	990,000.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5005900.00	5005900.00	00.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,632,500.00	1,632,500.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,373,400.00	3,373,400.00	00.00	100.0

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	488,751,300.00	482,395,418.53	6,355,881.47	98.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	433,898,600.00	428,648,083.15	5,250,516.85	98.8
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	433,898,600.00	428,648,083.15	5,250,516.85	98.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,852,700.00	53,747,335.38	1,105,364.62	98.0
132001	Орон нутгийн төсвөөс	54,852,700.00	53,747,335.38	1,105,364.62	98.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /
		Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,073,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,073,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,973,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,311,800.00
210402	Тээвэр, шатахуун	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	573,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	688,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	422,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	422,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2073800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,073,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	812,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ихэр мөрөн аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг нэвтрүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагаанд бие даан суралцах арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 492.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.8 сая төгрөгөөр буюу 1.02 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

/Сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	3.7	00	(3,7)
Урьдчилгаа	00	00	
Бараа материал	74.7	73.1	(1,6)
Үндсэн хөрөнгө	689.9	711.0	21,1
Нийт хөрөнгө	768.3	784.1	15,8
Өр төлбөр	00	00	00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	768.3	784.1	15,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	768.3	784.1	15,8

Авлага данс үлдэгдэлгүй байна. Өмнөх оны бэлтгэн нийлүүлэгчээс авах хүнсний материалын авлагыг бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73.1 сая төгрөг болж 1,6 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 28.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 4.7 сая төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас хичээлийн жилд бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгсэл 2.6 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж үйл ажиллагаанд 37.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 711.0 сая төгрөг болж 21.1 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан машин тоног төхөөрөмж дансанд 19.5 сая төгрөгөөр зөөврийн компьютер, принтер, утаа мэдрэгч, тавилга эд хогшил дансанд сургалтын хэрэглэгдэхүүн ширээ, сандал, хивс 6.3 сая төгрөгийн хөрөнгийг Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авч бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, “0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 30 нэр төрлийн 36.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 18.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 21 нэр төрлийн 9.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан.

Хуримтлагдсан элэгдэл дансанд 24.5 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 784.1 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 15.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 23.2 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих санхүүжилт 16.7 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн дүн 10.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 15.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь хоол хүнс, бараа үйлчилгээний бусад зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 505.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор тодотгол хийж төсвийг 29.3 сая төгрөгөөр бууруулж 475.8 сая төгрөг тогтоосон байна. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар нэг удаа нэмэх тодотголтой зохицуулалт хийж, тус

байгууллагын төсвийг 13.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 488.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

2021 оны төсвийн гүйцэтгэлийг 482.4 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 488.8 сая төгрөгтэй харьцуулахад 98.7 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 6.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад 22.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны авлага 0.2 сая төгрөг, тендерийн орлого 0.1 сая төгрөг, Мөрөн сумаас Ковид-19 вакцины цэгийн хоолонд 0.3 сая төгрөг, урсгал зардалд 1.5 сая төгрөг нийт 2.1 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны хүүхдийн хоолны хүнсний материалаас Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/254 захирамжийн дагуу Мөрөн сумын ЗДТГ-аас Мөрөн сумын цэцэрлэгүүдэд Ковид-19 цар тахлын үеийн эргүүлийн пост, вакцин хийж байгаа эмч нарын хоолыг хийх хуваарь гаргасны дагуу тус цэцэрлэг 1.6 сая төгрөгийн хүнсний материалаар хоол бэлтгэн хүргүүлсэн байна. Мөрөн сумын ЗДТГ-аас хоолны материалын үнэ 0.3 сая төгрөгийг тухайн байгууллагын дансанд шилжүүлж 1.3 сая төгрөг дутуу байгааг анхаарал хандуулах гол асуудал гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэг нь 2021 онд нийт 604.4 сая төгрөгийн 69 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 604.4 сая төгрөгийн 69 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 33.5 сая төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хүүхдийн 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан тасалбар болгосон ба тайланг батламжилсан өдрийн хооронд тайланд нөлөө үзүүлж болохуйц үйл явдал болоогүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардал данснаас багш нарын баярт зориулан зохион байгуулсан уралдаан тэмцээний шагналын мөнгө, медал өргөмжлөлд нийт 1.4 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6-д Засгийн газрын шийдвэр гарснаас

бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ Сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9 дүгээр цэцэрлэг	1	1.4	-	-	-	-	-	-	1	1.4

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо:

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо: 2.22

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

